

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/32/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер:И.Эрдэнэцэцэг Утас: 51-260512 Цахим хаяг: Erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Лхагвацэнд Утас:51-261628 Цахим хаяг: Lhkagvatsendb@audit.gov.mn Гэрээгээр гүйцэтгэсэн Azure хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	4
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ө.ЛУВСАНРЕНЧИН ТАНАА

2026.03.16 № 06/722
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 1,857.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, гүйцэтгэлээр нэр бүхий 11 байгууллагатай 1,541.9 сая төгрөгийн Худалдах, худалдан авах болон Засварын ажлын гэрээ байгуулж зардлыг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэн гэрээний хэрэгжилтийг тухай бүр дүгнэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нийт 9,678.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 9,832.7 сая төгрөгийн зардал тайлагнаж, 154.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудал

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДД	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,633,004,327.93	2,340,317,587.37
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	НДШ – ийн авлага	9,740,276.45	5,245,772.40
1.1.4	Бусад авлага	11,939,402.85	911,685,573.06
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	790,746,756.72	781,902,931.58
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,445,430,763.95	4,039,151,864.41
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,598,699,901.38	4,643,736,528.63
1.2.2	Биет бус хөрөнгө	696,863,320.31	690,717,369.70
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,295,563,221.69	5,334,453,898.33
1.3	ДҮН	9,740,993,985.64	9,373,605,762.74
2	ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	21,319,246.00	682,651.50
2.1.1.3	Татварын өр	71,440,810.29	42,191,303.24
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	5,000.00	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	17,771,200.00	18,521,200.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	110,536,256.29	61,395,154.74
2.2	Өр төлбөрийн нийт дүн	110,536,256.29	61,395,154.74
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч:	7,955,637,235.90	7,955,637,235.90
2.3.1.1	төрийн	7,955,637,235.90	7,955,637,235.90
2.3.3	Нэмж төлөгдсөн капитал	757,597,449.00	757,597,449.00
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,248,329,224.49	3,248,329,224.49
2.3.6	Эздийн өмчийн бусад хэсэг	1,057,767,155.91	1,057,767,155.91
2.3.7	Хуримтлагдсан ашиг	(3,388,873,335.95)	(3,707,120,457.30)
2.3.9	Эздийн өмчийн дүн	9,630,457,729.35	9,312,210,608.00
2.4	ДҮН	9,740,993,985.64	9,373,605,762.74
1	Актив	9,740,993,985.64	9,373,605,762.74
2	Пассив	9,740,993,985.64	9,373,605,762.74

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДД	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,398,003,137.71	9,397,504,504.42
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8,766,698,931.55	9,585,407,706.70
3	Нийт ашиг (алдагдал)	(368,695,793.84)	(187,903,202.28)
5	Хүүний орлого	248,852,196.93	268,626,872.32
8	Бусад орлого	540,909.09	572,727.27
10	Ерөнхий ба удирдлагын зардал	258,336,456.60	220,472,587.76
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	5,445,587.67	11,428,120.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(372,193,556.75)	(127,748,070.45)
19	Орлогын татварын зардал	24,885,219.70	26,862,687.26
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(397,078,776.45)	(154,610,757.71)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(397,078,776.45)	(154,610,757.71)
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(397,078,776.45)	(154,610,757.71)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,771,001,840.81	3,248,329,224.49	3,248,329,224.49	1,057,767,155.91	(2,991,794,559.50)	10,027,536,505.80
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	(397,078,776.45)	(397,078,776.45)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,771,001,840.81	3,248,329,224.49	3,248,329,224.49	1,057,767,155.91	(3,388,873,335.95)	9,630,457,729.35
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	(163,636,363.64)	(163,636,363.64)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,771,001,840.81	3,248,329,224.49	3,248,329,224.49	1,057,767,155.91	(3,552,509,699.59)	9,466,821,365.71
19	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	(154,610,757.71)	(154,610,757.71)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,771,001,840.81	3,248,329,224.49	3,248,329,224.49	1,057,767,155.91	(3,707,120,457.30)	9,312,210,608.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДД	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	9,244,692,308.50	9,451,467,721.76
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,103,027,249.00	9,276,780,740.30
1.1.6	Бусад мөнгөн орлого	141,665,059.50	174,686,981.46
1.2	Мөнгөн зарлагын дүн	8,930,756,678.78	9,995,169,152.82
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,225,813,660.00	3,644,994,752.48
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	854,495,634.78	900,044,064.96
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,836,902,608.30	1,781,369,047.19
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,800,781,675.21	2,118,971,807.96
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,402,700.00	3,300,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	799,981,846.74	939,539,844.69
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	410,378,553.75	606,949,635.54
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	313,935,629.72	(543,701,431.06)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	248,852,196.93	268,626,872.32
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	248,852,196.93	268,626,872.32
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	44,362,908.92	17,612,181.82
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	44,362,908.92	17,612,181.82
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	204,489,288.01	251,014,690.50
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3.4	Валютын ханшийн зөрүү	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	518,424,917.73	(292,686,740.56)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,114,579,410.20	2,633,004,327.93
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,633,004,327.93	2,340,317,587.37

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Эдийн засгийн зорилтот үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	8,652,841.8	9,018,000.0	9,678,132.2	(660,132.2)	107.3
Төсөвт байгууллагад үзүүлсэн ажил үйлчилгээний орлого	8,233,613.9	8,645,000.0	9,186,926.5	(541,926.5)	106.3
Өмчийн орлого	27,922.6	28,000.0	29,266.3	(1,266.3)	104.5
Бусад орлого	137,007.6	85,000.0	181,884.4	(96,884.4)	214.0
Хүүгийн орлого	248,852.2	260,000.0	268,626.9	(8,626.9)	103.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	5,445.6		11,428.1	(11,428.1)	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	9,049,920.6	9,948,371.2	9,832,743.0	115,628.3	98.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,970,179.5	9,860,071.2	9,753,567.2	106,504.1	98.9
Цалин хөлсний зардал	4,375,510.0	5,298,056.4	4,884,464.4	413,592.0	92.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,924,486.2	4,709,383.5	4,411,446.2	297,937.3	93.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	451,023.7	588,672.9	473,018.3	115,654.7	80.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,550,276.4	1,954,017.8	1,927,169.7	26,848.1	98.6
Гэрэл, цахилгаан	999,840.8	1,299,793.1	1,309,936.8	(10,143.7)	100.8
Түлш, халаалт	407,379.8	509,224.7	476,820.7	32,404.1	93.6
Цэвэр, бохир ус	143,055.8	145,000.0	140,412.3	4,587.7	96.8
Хангамж, бараа материалын зардал	641,087.0	543,090.9	613,823.3	(70,732.4)	113.0
Бичиг хэрэг	8,334.2	8,000.0	15,833.4	(7,833.4)	197.9
Тээвэр, шатахуун	2,884.3	2,800.0	4,452.2	(1,652.2)	159.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,403.8	5,600.0	6,862.0	(1,262.0)	122.5
Ном, хэвлэл	181.8	190.9	-	190.9	-
Хог хаягдал зайлуулах	48,109.1	53,000.0	34,100.0	18,900.0	64.3
Хортон мэрэгчдийн устгал ариутгал	2,052.6	3,500.0	5,503.6	(2,003.6)	157.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	574,121.3	470,000.0	547,072.1	(77,072.1)	116.4
Нормативт зардал	21,157.1	21,245.3	7,189.1	14,056.2	33.8
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	245.3	245.3	-	245.3	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,911.8	21,000.0	7,189.1	13,810.9	34.2
Эд хогшил, урсгал засварын зардал	1,068,310.7	585,000.0	1,011,462.8	(426,462.8)	172.9
Багаж, техник, хэрэгсэл	23,778.1	25,000.0	5,616.2	19,383.8	22.5
Урсгал засвар	1,044,532.6	560,000.0	1,005,846.6	(445,846.6)	179.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	255,612.5	353,660.9	282,572.9	71,088.0	79.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,961.8	13,560.0	12,006.1	1,553.9	88.5
Даатгалын үйлчилгээ	-	546.0	590.3	(44.3)	108.1
Тээврийн хэрэгслийн татвар	181.6	600.0	561.4	38.6	93.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	227.5	250.0	258.6	(8.6)	103.4
Татварын зардал	24,885.2	26,000.0	26,862.7	(862.7)	103.3
Газрын төлбөр	4,418.4	4,418.4	4,425.9	(7.5)	100.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,358.1	8,286.5	8,087.6	198.8	97.6
Харуул хамгаалалтын зардал, БГАҮ	202,579.9	300,000.0	229,780.3	70,219.7	76.6
Бараа үйлчилгээний бусад зардал	1,058,225.9	1,105,000.0	1,026,885.0	78,115.0	92.9
Бараа, үйлчилгээний бусад зардал	46,043.6	45,000.0	39,160.9	5,839.1	87.0
Элэгдлийн зардал	998,382.3	1,050,000.0	978,721.5	71,278.5	93.2

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	13,800.0	10,000.0	9,002.5	997.5	90.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,741.2	88,300.0	79,175.8	9,124.2	89.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,364.0	40,300.0	61,975.8	(21,675.8)	153.8
Нэг удаагийн буцалтгүй тусламж	13,957.1	20,000.0	3,850.0	16,150.0	19.3
Шагнал урамшуулал	28,420.0	28,000.0	13,350.0	14,650.0	47.7
Үйл ажиллагааны үр дүн	(397,078.8)	(930,371.2)	(154,610.8)	(775,760.5)	16.6
Авлага	21,679.7		916,931.3		
Өглөг	110,536.3		61,395.2		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ нь төрийн ордон болон Засгийн газруудын байруудын ашиглалт, засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, харуул хамгаалалт, инженер, техникийн хэвийн ажиллагааг хариуцан, үйлчлүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

Үндсэн чиг үүрэг:

- **Инженер, техникийн үйлчилгээ:** Байруудын цахилгаан, дулаан, ус, агааржуулалт, сантехникийн хэвийн ажиллагааг хангах, засварлах;
- **Ашиглалт, засвар:** Засгийн газрын байруудын өрөө, коридор, нийтийн эзэмшлийн талбайн засвар, үйлчилгээг стандартад нийцүүлэн хийх;
- **Цэвэрлэгээ, үйлчилгээ:** Байруудын доторх цэвэрлэгээ, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ, хог хаягдлын менежментийг хариуцах;
- **Харуул хамгаалалт:** Байруудын аюулгүй байдлыг хангах, нэвтрэх журмын хэрэгжилтийг хянах;
- **Түгээмэл үйлчилгээ:** Байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай дэд бүтэц, орчныг бүрдүүлэх, гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэх.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гаргасан байна.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант хугацаанд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын автомашины элэгдэл, үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөний биелэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж, сайжруулах үүрэг чиглэл өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж, ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 367.4 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,633,004.3	2,340,317.6	(292,686.7)
Авлага	21,679.7	916,931.4	895,251.7
Бараа материал	790,746.8	781,902.9	(8,843.9)
Үндсэн хөрөнгө	6,295,563.2	5,334,453.9	(961,109.3)
Нийт хөрөнгө	9,740,994.0	9,373,605.8	(367,388.2)
Өглөг	110,536.3	61,395.2	(49,141.1)
Эздийн өмч	9,630,457.7	9,312,210.6	(318,247.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,740,994.0	9,373,605.8	(367,388.2)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,340.3 сая төгрөг болж, өмнөх оны үлдэгдлээс 292.7 сая төгрөгөөр буурсан нь түрээсийн авлага нэмэгдэж мөнгөн хөрөнгийн орлого буурснаас шалтгаалсан;
- Авлагын дансны үлдэгдэл 916.9 сая төгрөг болж, 895.2 сая төгрөгөөр нэмэгдсэн төсөвт байгууллагуудаас авах түрээсийн авлага нэмэгдсэнтэй холбоотой. Авлагын үлдэгдэлд түрээсийн авлага 911.7 сая төгрөг, татварын авлага 5.2 сая төгрөг байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 781.9 сая төгрөг болж, 8.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 1,011.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан, Эдийн засаг, хөгжлийн яамнаас 11.4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч,

үйл ажиллагаандаа 1,005.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, Өмч хамгаалах комиссын шийдвэрээр 25.9 сая төгрөгийн материал акталсантай холбоотой;

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,334.5 сая төгрөг болж, 961.1 сая төгрөгөөр буурсан нь:
 - ✓ Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
 - ✓ Авто тээврийн хэрэгсэлд хийсэн 11.4 сая төгрөгийн засварыг капиталжуулж үнийг нэмэгдүүлсэн;
 - ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 344 болон 842 дугаар тогтоолоор элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн нийт 113.2 сая төгрөгийн хөрөнгө акталсан;
 - ✓ Тайлант хугацаанд 978.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой;
- Өглөг дансны үлдэгдэл 61.4 сая төгрөг болж, 49.1 сая төгрөгөөр буурсан нь нэмэгдсэн өртгийн албан татварын 71.4 сая төгрөгийн өглөг буурсантай холбоотой
- Эздийн өмч дансны үлдэгдэл 9,312.2 сая төгрөг болж, 318.2 сая төгрөгөөр буурсан нь:
 - ✓ Тайлант хугацааны 154.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
 - ✓ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамд Үндэсний аудитын газраас тогтоосон 180.0 сая төгрөгийн актыг төлөхдөө 2024 онд орлогоор хүлээн зөвшөөрсөн тул нэмэгдсэн өртгийн албан татваргүй дүн болох 163.6 сая төгрөгийг өмнөх оны хуримтлагдсан үр дүнгээс бууруулж бүртгэсэнтэй холбоотой.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад 24.2 сая төгрөгийн үнэ бүхий 7 программыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Санхүүгийн программыг хөгжүүлэхтэй холбоотой зардал 2025 онд гараагүй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагынхаа 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд нийт орлогыг 9,018.0 сая төгрөг, нийт зардлыг 9,948.4 сая төгрөг, 930.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 9,678.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 9,832.7 сая төгрөгийн зардал гарган 154.6 сая төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөө 660.1 сая төгрөг буюу 7.3 хувиар давж биелсэн, зардал төлөвлөснөөс нийт дүнгээрээ 115.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан.

Тайлант онд 154.6 сая төгрөгийн алдагдалтай гарч төлөвлөснөөс 775.8 сая төгрөгөөр бага байгаа нь борлуулалтын орлого 660.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу зарим зардлуудыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Байгууллагын орон тооны цомхотгол: Тус байгууллагын батлагдсан орон тоо 273 байхад гүйцэтгэлээр 233 орон тоотой ажиллаж байна. Цалингийн зардлыг 4,709.3

сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,411.4 сая төгрөгийг зарцуулж, 297.9 төгрөгийг дутуу зарцуулсан байна;

- Байгууллагын дотоод журмын 9.1.5-д заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар ажилчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 7.0 мянган төгрөгөөр, унааны төлбөрийг 1.0 мянган төгрөгөөр баталж, тайлант онд унаа хоолны хөнгөлөлтийн зардалд нийт 408.8 сая төгрөгийг зарцуулсан;
- Гадаад томилот, хэвлэл мэдээллийн зардлыг төлөвлөөгүй;
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй болно.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ТӨААТҮГ нь тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 1,857.7 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөснөөс бараа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн асуудлаар нэр бүхий 11 байгууллагатай “Худалдах, худалдан авах гэрээ”, “Засварын ажлын гэрээ” байгуулан, өөрийн эх үүсвэрээс 1,541.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэн гэрээний хэрэгжилтийг тухай бүр дүгнэж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой, хөрөнгийн бүртгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Азуре хүлүг аудит” ХХК-ийн аудитор Д.Мөнхзул гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер П.Болортуяа, захирал Г.Мөнхбаяр, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Лхагвацэнд, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 9,025.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 90.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 36 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэхэд зөрчил, дутагдал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 789.9 сая төгрөгийн 4 зөрчил илэрсэнд, 93.4 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хүргүүлж, 696.6 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар нь Шилэн дансны цахим системд оруулбал зохих 158 мэдээллээс 153 нь хугацаандаа, 1 хугацаа хоцроосон, 180.0 сая төгрөгийн 1 мэдээлэл оруулаагүй, хугацаа нь болоогүй 3 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр:", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:", гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны үйлдвэр, санхүүжилтийн төлөвлөгөөний суурь үзүүлэлтийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй харьцуулан боловсруулаагүй, гүйцэтгэлээр хангамж, бараа материалын зардлыг 70.7 сая төгрөг, урсгал засварын зардлыг 445.8 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зорилтот түвшний төлөвлөгөө батлуулахдаа орлого, зардлын суурь үзүүлэлтийг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулж, оновчтой төлөвлөж, батлуулж байх зөвлөмж өгсөн;

Илрүүлэлт 2:

- Тайлант хугацаанд харьцуулалтын арга хэрэглэхээс зайлсхийж Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолын дагуу төсөвт өртгийн дээд хязгаараас бууруулж 1 хуулийн этгээдтэй 4 удаа нийт 67.3 сая төгрөгийн гэрээ байгуулж шууд худалдан авалт хийсэн.
- Автомашины урсгал засварын ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хуулийн дагуу зохион байгуулалгүйгээр нийт 26.1 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 35 дугаар зүйлийн 35.2-д "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьцуулалтын арга хэрэглэхээс зайлсхийж, төсөвт өртгийг жижиглэн хувааж, шууд худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулсан. Аудитаар 0.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн нь биелсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5,721.1	2	5,721.1	100.0
Нийт дүн	2	5,721.1	2	5,721.1	100.0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар санхүүгийн ажилчдад балансын урамшуулал олгосон эсэх, худалдан авах ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 40.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 36.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлагыг хүргүүлж, 0.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 40.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 49.8 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд хавсралтад дурдсан нэр бүхий 10 ажилтанд нийт 2.9 сая төгрөгийн цалин илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдад илүү олгосон 2.9 сая төгрөгийн цалинг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Удирдлага болон санхүүгийн нийт 9 ажилчдад захирлын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар 2025 оны эхний хагас жилийн балансын урамшуулалд 36.6 сая төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт 1: Тайлант хугацаанд автомашины засварын зардлаас 11.4 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн дансанд тээврийн хэрэгслийн үнийг нэмэгдүүлж капиталжуулж бүртгэсэн боловч 0.9 сая төгрөгийн элэгдэл бодоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-т "бүх орлого", 14.4.6-д "бүх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зардал", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг элэгдлийг бүрэн байгуулж, санхүүгийн тайланд бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Тайлант онд хавсралтад дурдсан нэр бүхий 10 ажилтанд нийт 2,872.9 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.	1	2,872.9	1	2,872.9	-	-	-	-	-	-
Захирал болон санхүүгийн нийт 9 ажилчдад захирлын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар 2025 оны эхний хагас жилийн балансын урамшуулалд 36,643.4 мянган төгрөгийг олгосон байна.	1	36,643.4	-	-	1	36,643.4	-	-	-	-
Тайлант хугацаанд автомашины засварын зардлаас 11,388.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн дансанд тээврийн хэрэгслийн үнийг нэмэгдүүлж капиталжуулж бүртгэсэн боловч 879.3 мянган төгрөгийн элэгдэл бодоогүй.	1	879.3	-	-	-	-	1	879.3	-	-
Дүн	3	40,395.6	1	2,872.9	1	36,643.4	1	879.3	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар нь Шилэн дансны цахим системд оруулбал зохих 158 мэдээллээс 153 нь хугацаандаа, 1 хугацаа хоцроосон, 180,000.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл оруулаагүй, хугацаа нь болоогүй 3 мэдээлэл байна.	1	180,000.0	-	-	-	-	-	-	1	180,000.0
Дүн	1	180,000.0	-	-	-	-	-	-	1	180,000.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны үйлдвэр, санхүүжилтийн төлөвлөгөөний суурь үзүүлэлтийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй харьцуулан боловсруулаагүй, гүйцэтгэлээр хангамж, бараа материалын зардлыг 70,732.3 мянган	1	516,578.9							1	516,578.9

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ТӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

төгрөг, урсгал засварын зардлыг 445,846.4 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.								
Тайлант хугацаанд харьцуулалтын арга хэрэглэхээс зайлсхийж Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолын дагуу төсөвт өртгийн дээд хязгаараас бууруулж 1 хуулийн этгээдтэй 4 удаа нийт 67,283.6 мянган төгрөгийн гэрээ байгуулж шууд худалдан авалт хийсэн.	1	67,283.6			1	67,283.6		
Автомашин урсгал засварын ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хуулийн дагуу зохион байгуулалгүйгээр нийт 26,098.6 сая төгрөгийг зарцуулсан.	1	26,098.6			1	26,098.6		
Дүн	3	609,961.1	-	-	2	93,382.2	1	516,578.9
Нийт дүн	4	789,961.1	-	-	2	93,382.2	2	696,578.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 892/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТӨА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нэр бүхий 1 компанитай 4 удаагийн гэрээгээр төсөвт өртгийг хуваан нийт 67,283,664.00 /Жаран долоон сая хоёр зуун наян гурван мянга зургаан зуун жаран дөрвөн/ төгрөгийн шууд худалдан авалт хийж, худалдан авах ажиллагааны харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй.
2. Мөн автомашины урсгал засварын ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хуулийн дагуу зохион байгуулалгүйгээр нийт 26,098,600.00 /хорин зургаан сая ерэн найман мянга зургаан зуун/ төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно"; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална"; 10 дугаар зүйлийн 10.12-т "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно"; 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална"; Монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн 02 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" журам, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 20 сая төгрөг" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчиж, төсөвт өртгийн хязгаарсан давсан худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын захирал (Ө.Лувсанренчин), ахлах нягтлан бодогч (Д.Отгонпүрэв) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 891/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТӨА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Удирдлага болон санхүүгийн албаны ажилчдад улирал бүр үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч балансын урамшуулал гэж 9 ажилтанд нийт 36,643,400.00 (гучин зургаан сая зургаан зуун дөчин гурван мянга дөрвөн зуу) төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 1-д Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын захирал (Ө.Лувсанренчин), ахлах нягтлан бодогч (Д.Отгонпүрэв) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АЗУРЕ ХҮҮГ АУДИТ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 184/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нэр бүхий 10 ажилтанд нийт 2,872,874.00 (хоёр сая найман зуун далан хоёр мянга найман зуун далан дөрөв) төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын хавсралтад дурдсан 10 ажилчдад илүү олгосон нийт 2,872,874.00 (Хоёр сая найман зуун далан хоёр мянга найман зуун далан дөрөв) төгрөгийг Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын цалингийн нягтлан бодогч Б.Гэндэндарам, Ерөнхий нягтлан бодогч Д.Отгонпүрэв, захирал Ө.Лувсанренчин, нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын захирал (Ө.Лувсанренчин), Ерөнхий нягтлан бодогч Д.Отгонпүрэв нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР

